



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 10000

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас хийгдэх ой, хээрийн түймэр, хууль бус мод, хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх болон хорио цээр тогтоосон үед явуулын хяналтын пост ажиллуулахад шаардлагатай вагончик худалдан авах ажлыг “Арвайн зам транс” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. “Арвайн зам транс” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ой, хээрийн түймэр, хууль бус мод, хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх болон хорио цээр тогтоосон үед явуулын хяналтын пост ажиллуулахад шаардлагатай вагончик худалдан авах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Зардалд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг гэрээнд заасны дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН